



Иргэний нисэхэд хэрэглэдэг нэр томъёоны тодорхойлолт болон товчлолын талаар

ДҮРЭМ БОЛОВСРУУЛАЛТЫН ТАСАГ

Улаанбаатар хот



Иргэний нисэхэд хэрэглэдэг нэр томьёо

ИНД-ийн нэр томьёо, товчлол			Annex-ын нэр томьёо, товчлол		
	ИНД-ийн нэр томьёоны тайлбар	ИНД-1 Тодорхойлолт ба товчлол	MNS 6409 : 2023: Annex-ын нэр томьёоны тайлбар	MNS 6409 : 2015 Ерөнхий Нэр томьёо, тодорхойлолт	AIP GEN 2.2 НМҮ-д ашиглагдах товчлолууд
Тодорхойлолт	550	618	1010	781	-
Товчлол	194	79	1130	-	1079

ИНД-ийн нэр томьёоны тайлбар

- ❖ 2022 оны 4 сарын 22-нд ЗТХСайдын А/94 тоот тушаалаар батлагдсан “**ИНД-ийн нэр томьёоны тайлбар**” нь өмнө ашиглаж байсан **ИНД-1 “Тодорхойлолт ба товчлол”**-ын шинэчилсэн хувилбар бөгөөд 2019, 2021 онуудад батлагдсан ИНД-үүдэд орсон нэр томьёотой бүрэн уялдаа холбоотой болсон.

Annex-ын нэр томьёоны тайлбар

- ❖ 2018 - 2021 онуудад боловсруулан холбогдох хэлэлцүүлгийг хийж, ИНЕГ-ын даргаар батлуулахаар бэлтгэсэн “**Annex-ын нэр томьёоны тайлбар**” нь өмнө ашиглаж байсан дараах 2 баримт бичгийн агууламжийг бүрэн хамардаг ба Annex-ууд болон “Doc 8400 ICAO Abbreviations and Codes”-н сүүлийн нэмэлт, өөрчлөлтийг тусгасан баримт бичиг юм:
 - **MNS 6409 : 2015 Иргэний нисэхийн Ерөнхий Нэр томьёо, тодорхойлолт;**
 - **AIP GEN 2.2 НМҮ-ний хэвлэлүүдэд ашиглагдах товчлолууд.**



Эрх зүйн баримт бичгийн нэр томъёоны талаар

❖ Иргэний нисэхийн тухай хууль:

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог дараахь утгаар ойлгоно:

❖ ИНД-ийн нэр томъёоны тайлбар:

1.1. Нэр томъёо

Хуулийн дагуу боловсруулсан ИНД-д хэрэглэсэн нэр томъёог дараахь утгаар ойлгоно:

❖ Annex-ын нэр томъёоны тайлбар Зорилго

“Annex-ын нэр томъёоны тайлбар” нь ICAO Annex-ын тодорхойлолт болон ICAO Doc 8400-ийн товчлолыг нэгдсэн нэг утгаар ойлгох нөхцөлийг бий болгох зорилготой.

Энэхүү “Annex-ын нэр томъёоны тайлбар” нь иргэний нисэхийн салбарын үйл ажиллагаа эрхлэгчид Annex-тай холбоотой баримт бичгийг орчуулж, хэрэглэх, тайлбарлахад зориулагдсан.

❖ Annex:

Annex 1 Personnel Licensing 1.1 Definitions

When the following terms are used in the Standards and Recommended Practices for Personnel Licensing, they have the following meanings:

Annex 15 Aeronautical Information Services 1.1 Definitions

When the following terms are used in the Standards and Recommended Practices for the AIS, they have the following meanings:



Эрх зүйн баримт бичгийн нэр томъёоны талаар (үргэлжлэл)

❖ **Хууль тогтоомжийн тухай хууль:**

28.3.Хуулийн төслийн бүтцийг дараах дарааллаар байрлуулна:

28.3.1. хуулийн төслийн гарчиг;

28.3.2. нийтлэг хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн "ерөнхий анги", эсхүл "нийтлэг үндэслэл" гэсэн бүлэг, хэсэг;

28.3.3. нэр томъёоны тайлбар; ...

30.5.Хуулийн төсөлд дараах тохиолдолд гадаад хэлний нэр томъёо хэрэглэж болно:

30.5.1. уг нэр томъёог оноосон нэр монгол хэлэнд байхгүй бол;

30.5.2. уг нэр томъёог олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэж хэвшсэн бол;

30.5.3. уг нэр томъёог Монгол Улсын олон улсын гэрээнд хэрэглэж байгаа бол.

❖ **Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал**

Зөвлөмж: Хэрэглэж хэвшсэн нэр томъёонд тайлбар хийхгүй бөгөөд дагаж мөрдөж байгаа бусад хуульд тайлбарласан нэр томъёог уг хуульд ишлэл хийх замаар хэрэглэнэ.

4.1.4.2. хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо нь олон утгаар ойлгогдох тохиолдолд тухайн бүлэг, зүйл, хэсэг, заалтын хүрээнд хэрэглэгдэх тайлбарыг холбогдох бүлэг, зүйлийн дор байрлуулна.



Аннех-уудад ч зарим нэр томъёог өөр өөр хэрэглэдэг

Тодорхойлолт	Англи
Pilot-in-command / Хөлгийн дарга	(A) The pilot designated by the operator, or in the case of general aviation, the owner, as being in command and charged with the safe conduct of a flight. <u>(AN 1, AN 2, AN 3, AN 6/I, AN 6/II, AN 6/III, AN 11, AN 18, PANS-ATM)</u> (B) The pilot responsible for the operation and safety of the aircraft during flight time. <u>(AN 9)</u>
Human performance / Хүний чадавх	(A) Human capabilities and limitations which have an impact on the safety and efficiency of aeronautical operations. <u>(AN 1; AN 5; AN 6/I; AN 6/III; AN 8; AN 10/I; AN 11; AN 14/I; AN 16/I)</u> (B) Human capabilities and limitations which have an impact on the safety, security and efficiency of aeronautical operations. <u>(AN 17)</u>
Quality system / Чанарын тогтолцоо	(A) Documented organizational procedures and policies; internal audit of those policies and procedures; management review and recommendation for quality improvement. <u>(AN 1)</u> (B) A management system in which the competent laboratory documents its policies, systems, programmes, procedures and instructions to the extent necessary to assure the quality of the test and/or calibration results. <u>(AN 16/II)</u>
Altitude / Өндрийн-түвшин	(A) The vertical distance of a level, a point or an object considered as a point, measured from mean sea level (MSL). <u>(AN 2; AN 3; AN 4; AN 10/I; AN 10/II; AN 11; PANS-ATM; PANS-OPS/II)</u> (B) Altitude. The altitude at which the aeroplane is flown affects the fuel flow. <u>(AN 16/III)</u>
Duty / Үүрэг	(A) Duty. Any task that flight or cabin crew members are required by the operator to perform, including, for example, flight duty, administrative work, training, positioning and standby when it is likely to induce fatigue. <u>(AN 6/I)</u> (B) Duty. Any task that an air traffic controller is required by an air traffic services provider to perform. These tasks include those performed during time-in-position, administrative work and training. <u>(AN 11)</u>
Duty Period / Үүрэгт хугацаа	(A) A period which starts when a flight or cabin crew member is required by an operator to report for or to commence a duty and ends when that person is free from all duties. <u>(AN 6/I; AN 6/III)</u> (B) A period which starts when an air traffic controller is required by an air traffic services provider to report for or to commence a duty and ends when that person is free from all duties. <u>(AN 11)</u>



Annex болон ИНД-ийн зөрүүг мэдээлэх

Annex болон ИНД-ийн зөрүүг мэдээлэх ажил нь ДБТ-ийн 2022-2023 оны төлөвлөгөөнд ордог боловч 2018 оны “ИНЕГ-аас ICAO болон олон улсын бусад байгууллагатай харилцах журам”-ын дагуу зөрүүг тодорхойлох ажил нь НААХЗА-ны чиг үүрэгт багтдаг. ДБТ нь НААХЗА-наас тодорхойлон гаргасан зөрүүг томилогдсон мэдээлэгчийн хувьд AIP-д мэдээлэх үүрэг хүлээдэг.

Annex болон ИНД-ийн зөрүүг тодорхойлох ажлын эхлэл болох 20-50% нь Annex-ийн нэр томъёотой холбоотой байдаг бөгөөд 2022 оны 4 сард Даргын тушаалаар батлуулахаар хүргүүлсэн “Annex-ийн нэр томъёоны тайлбар” батлагдахгүй удааширч байгаагаас шалтгаалан НААХЗА чиг үүргийнхээ дагуу зөрүүг тодорхойлох ажлыг гүйцэтгэж дуусгахгүй байгаа тул зөрүүг AIP-аар мэдээлүүлэх ДБТ-ийн төлөвлөгөөнд орсон ажил хүлээгдэж байна.

Конвенцын зүйл 38. Олон улсын стандарт, журмаас зөрүүтэй хэрэглэх

Олон улсын аливаа стандарт, журмыг бүх талаар биелүүлэх боломжгүй гэж үзсэн ... хүндрэлтэй гэж үзсэн, эсхүл ... зөрүүтэй дүрэм, эсхүл хэм хэмжээг батлан хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн улс өөрийн мөрдөж буй хэм хэмжээ болон олон улсаас тогтоосон стандарт хоорондын **зөрүүний талаар ICAO-д нэн даруй мэдэгдэнэ.**



Annex болон ИНД-ийн зөрүүг мэдээлэх

“Annex-ын нэр томъёоны тайлбар” нь батлагдахгүй удааширч байгаа нь ICAO USOAP CMA-н асуулга бөглөх, ээлжит Аудит шалгалтад бэлтгэх болон Annex, ИНД-ийн зөрүүг мэдээлэх зэрэг ажлуудыг саатуулж байгаа тул **“Annex-ийн нэр томъёоны тайлбар”-ыг яаралтай батлан гаргах шаардлагатай байна.**

- ❖ Зөвхөн Annex 4-н хувьд, ICAO-д Annex болон ИНД-ийн зөрүүг мэдээлэх ажлын хүрээнд тодорхойлох шаардлагатай нийт 729 стандарт, зөвлөмжөөс 118 нь нэр томъёоны тодорхойлолт байдаг бөгөөд энэ нь нийт ажлын 16% болдог.

Annex 4 Aeronautical charts

Level of implementation	Definition	Standard	Recommendation	Note	Total
Not Applicable	4			2	227
More Exacting or Exceeds	-	1	-	-	1
No difference	53			-	373
Different in character or OMOC	3	14	18	-	35
Less protective	58			-	93
Total	118	458	151	2	729

- ❖ Зөвхөн Annex 2-н хувьд, ICAO-д Annex болон ИНД-ийн зөрүүг мэдээлэх ажлын хүрээнд тодорхойлох шаардлагатай нийт 225 стандарт, зөвлөмжөөс 115 нь нэр томъёоны тодорхойлолт байдаг бөгөөд энэ нь нийт ажлын 51% болдог.

Annex 2 Rules of the air

Level of implementation	Definition	Standard	Recommendation	Total
Not Applicable	-	1	-	8
More Exacting or Exceeds	-	3	-	3
No difference	-	84	-	164
Different in character or OMOC	-	4	-	14
Less protective	-	18	-	36
Total	115	110	-	225



Дүгнэлт

Эрх зүйн баримт бичиг бүр өөрт хэрэглэсэн нэр томъёоны тайлбар болон товчлолыг агуулдаг.

“ИНД-ийн нисэхийн дүрмийн тайлбар”-т орсон 550 нэр томъёо болон “Annex-ын нэр томъёоны тайлбар”-т орсон 1011 нэр томъёоноос нийтдээ 16 нэр томъёо,

“ИНД-ийн нисэхийн дүрмийн тайлбар”-т орсон 194 товчлол болон “Annex-ын нэр томъёоны тайлбар”-т орсон 1137 товчлолоос нийтдээ 5 товчлол зөрүүтэй байгааг буруу гэж үзэх үндэслэлгүй байна.

Аливаа нэр томъёо болон товчлолыг тухайн баримт бичигт зориулан заасан утгаар нь хэрэглэдэг тул “ИНД-ийн нисэхийн дүрмийн тайлбар” болон “Annex-ын нэр томъёоны тайлбар” хоорондоо зөрчилдөхгүй.

Энэ асуудлаар 2023 оны 03 сарын 02-нд НААХЗА, ИНҮТ-ийн холбогдох албадуудтай уулзалт зохион байгуулж, Annex-ын нэр томъёоны тайлбарыг батлуулан, Annex-уудыг унших, орчуулахад ашиглах талаар нэгдсэн ойлголтод хүрсэн болохыг мэдэгдэхэд таатай байна.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА